

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-Д

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлд:

“ХҮИ.2. Монгол Улсын Ерөнхий сайдын Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагаатай танилцсан дүнгийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:

1. Салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах асуудлын хүрээнд Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ онд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд;
2. “Геологийн судалгааны төв” болон “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ыг Үндэсний геологийн албаны харьяанд ажиллуулах боломжийг судлан саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Үндэсний геологийн алба (О.Чулуун), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт;
3. Монгол Улсын Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, газрын тос дамжуулах хоолойн төслийн техникийн даалгаврыг боловсруулах, сонгон шалгаруулалт зарлах боломжтой эсэхийг судлан танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК (Д.Алтанцэцэг) нарт;
4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэлжүүлэх, түүнд тавих хяналтыг цахимжуулах эрх зүйн болон техникийн орчинг бүрдүүлэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолын 1, 2, 9 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд судлан зохих шийдвэрийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт;
5. Өмнийн говийн бүсэд хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын төслийн хүрээнд шаардагдах усны хэрэгцээг хэрхэн хангах асуудлыг судлан тодорхой шийдлийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, холбогдох аймгийн Засаг дарга нарт;

6. Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах чиглэлээр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт;

7. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн) нарт." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР